

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

**Гистафен 50мг шахмал (Gistafen 50mg tablet)**

**Сехифенадины гидрохлорид**

**Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө уг эм хэрэглэх зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулна.**

- Уг эм хэрэглэх зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд ямар нэгэн нэмэлт асуулт гарвал эмч болон эм зүйчээс асуугаарай.
- Уг бэлдмэл танд зориулагдсан учир шинж тэмдэг нь таныхтай адил байсан ч бусдад дамжуулж болохгүй. Учир нь тэдэнд хор хөнөөл учруулж болзошгүй.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө илэрч болно.

**Уг эм хэрэглэх зааварт:**

1. Гистафен гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
2. Гистафен бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
3. Гистафен бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
4. Илэрч болох гаж нөлөө
5. Гистафен бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
6. Савалтын агууламж болон бусад мэдээлэл

**1. Гистафен гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?**

Гистафен 50мг шахмал нь сехифенадины гидрохлорид агуулдаг бөгөөд энэ нь гистамины эсрэг эмийн бүлэгт хамарагдах ба гистамины эсрэг үйлдэл нь харшлын өвчний эмчилгээнд чухал серотонины эсрэг үйлдлээс илүү байна.

**Хэрэглэх заалт:**

- Бэлдмэлийг дараах цочмог болон архаг явцтай харшлын өвчний эмчилгээнд хэрэглэнэ.
  - Поллиноз (өвсний халууралт), харшлын гаралтай хамрын салст бүрхүүлийн үрэвсэл, хамар ба хамрын дайвар хөндийн эмгэг
  - Хоол хүнс, химийн бодис, тоосны харшил
  - Амьтны болон амьтанд хатгуулсны улмаас үүсэх харшил
  - Агаарын бохирдолтой холбоотой болон бусад харшил үүсгэгчээр үүсгэгдсэн харшил
- Харшлын шалтгаантай арьсны загатнаа буюу эсвэл бусад өвчний улмаас үүсэх загатнаа (харшлын ба атопик дерматит, васкулит, нейродермит, хавтгай улаан үлд гэх мэт)
- Харшлаас урьдчилан сэргийлэх (улирлын сэдрэлээс өмнө) ба барих эмчилгээнд

**2. Гистафен бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?**

Дараах тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхгүй.

- Бэлдмэлийн найрлага дахь үйлчлэгч бодис болон туслах бодист хэт мэдрэг хүмүүс

- Жирэмсэн үе
- Хөхүүл үе

Гистафеныг МАО ферментийг хориглогчтой (сэтгэл уналтын эмчилгээнд хэрэглэдэг эм) хамт хэрэглэхгүй.

#### **Дараах тохиолдолд тусгай болгоомжпол шаардагдана.**

Бөөрний эмгэг (эмчилгээг хамгийн бага эмчилгээний тунгаар эхэлнэ), хүнд явцтай зүрх судасны эмгэг, хоол боловсруулах замын болон элэгний эмгэгтэй өвчтөнд тус тус болгоомжтой хэрэглэх шаардлагатай.

Хүүхэд болон настангуудад хэрэглэсэн эмнэлзүйн судалгаа байдаггүй.

#### **Эмийн харилцан үйлчлэл:**

Хэрэв та ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж дуусаад удаагүй болон хэрэглэж байгаа, эсвэл хэрэглэх гэж байгаа бол (жоргүй олгодог эмүүд ч хамаарна) эмчлэгч эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй.

Гистамины эсрэг эмийг (сехифенадиныг оруулаад)monoаминоксидаза ферментийг хориглогч бэлдмэл хэрэглэж байгаа өвчтөнд хэрэглэхгүй.

Гистафен нь согтууруулах ундаа болон тайвшруулах эмийн ТМС-д үзүүлэх дарангуйлах нөлөөг ихэсгэдэггүй. Гэвч эмчилгээний явцад согтууруулах ундааны зүйл хэрэглэхээс зайлсхийнэ.

#### **Гистафеныг хоол хүнсний зүйлтэй хамт хэрэглэх нь**

Эмчилгээний явцад согтууруулах ундааны зүйл хэрэглэхээс зайлсхийнэ.

#### **Жирэмсэн болон хөхүүл үеийн хэрэглээ:**

Ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэхээсээ өмнө эмчлэгч эмчээсээ асууна.

Гистафеныг жирэмсэн үед хэрэглэхгүй.

Гистамины эсрэг бэлдмэлийг (гистафеныг оруу-лаад) хөхүүл үед хэрэглэхгүй.

#### **Жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:**

Хэрэв та уг бэлдмэлийг анх удаагаа хэрэглэж байгаа бол эхний удаа танд хэрхэн нөлөөлж байгааг шалгаарай. Зарим хүмүүс уг бэлдмэлд илүү мэдрэг байdag ба хэрэв нойрмоглох шинж илэрвэл жолоо барих болон машин механизмтай ажиллахаас зайлсхийнэ.

#### **Гистафены найрлага дахь зарим туслах бодистой холбоотой чухал мэдээлэл**

Гистафены шахмал бүр 302мг лактоз агуулдаг. Хэрэв танд эмч зарим төрлийн сахар зохидоггүй гэж хэлж байсан бол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчлэгч эмчтэйгээ зөвлөнө.

#### **3. Гистафен бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?**

Бэлдмэлийг байнга эмчлэгч эмч болон эм зүйчийн зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ. Хэрэв танд ойлгомжгүй зүйл байвал эмчлэгч эмч болон эм зүйч-тэйгээ шалгаарай.

Гистафены шахмалыг хангалттай хэмжээний шингэнээр даруулж хоолны дараа хэрэглээрэй.

**Насанд хүрэгсдэд:**

Цочмог болон архаг явцтай харшлын өвчин:

50-100мг тунгаар хоногт 2-3 удаа хэрэглэнэ. Эмчилгээний үр нөлөө эмчилгээг эхэлснээс хойш 1-3 өдрийн дотор илэрнэ.

Ээлж эмчилгээ өрөнхийдөө 5-15 хоног үргэлжилнэ. Шаардлагатай үед ээлж эмчилгээг давтана.

Харшлын эмгэгээс сэргийлэх (улирлын сэдрэлээс өмнө) болон барих эмчилгээ:

50мг тунгаар хоногт 2 удаа хэрэглэнэ. Бэлдмэлийг харшлын урвал эхлэхээс 2 долоо хоногийн өмнө хэрэглэнэ.

Гистафен 50мг шахмалыг дангаар нь болон бусад хэсэг газар нөлөөлдөг бэлдмэлтэй (хамрын дусаалга, нүдний дусаалга, тосон түрхэц) хамт хэрэглэж болно.

Хэрэв танд гистафен бэлдмэлийн үйлдэл хэт хүчтэй, эсвэл хэт сул санагдвал эмчлэгч эмч болон эм зүйчдээ мэдэгдээрэй.

**Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:**

Хэрэв та гистафен шахмалыг хэт их хэмжээгээр хэрэглэсэн бол яаралтай эмчид хандана. Хордлогын үед салст хуурайших, толгой өвдөх, бөөлжих, аюулхай орчим өвдөх, бусад хоол боловсруулах замын хямралын шинж илэрнэ.

**Хэрэв та гистафеныг хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол:**

Мартсан тунг нөхөхийн тулд тунг давхарлаж хэрэглэж болохгүй.

**4. Илэрч болох гаж нөлөө**

Бэлдмэлийг хэрэглэх үед бусад эмийн бэлдмэлийн нэгэн адилаар гаж нөлөө ажиглагдах боловч энэ нь бүх хүмүүст илэрдэггүй.

Гистафеныг 200мг ба түүнээс их тунгаар хэрэглэж байгаа үед (ялангуяа өлөн үед) ам хатах, хөнгөн явцтай аюулхай орчмын өвдөлт цөөн, хоол боловсруулах замын хямрал олон давтамжтай илэрч болно. Эдгээр гаж нөлөө нь хоол боловсруулах замын архаг өвчтэй хүнд ихсэж болно. Зарим тохиолдолд уг бэлдмэл нь хоолны дуршлыг ихэсгэдэг.

Гаж нөлөө нь эмчилгээний эхний хэдэн өдрийн дотор арилах ба гистафены эмчилгээг зогсоох болон тунг багасгах шаардлагагүй байдаг.

Эозинофиль эсийн тоо цөөрөх, бага зэрэг шээс хөөх, сарын тэмдгийн алдагдал, толгой өвдөх зэрэг гаж нөлөө ховор тохиолдоно.

Нойрмоглох шинж нь тунгаас хамаарна. Хоногт 150мг тунгаар хэрэглэж байгаа үед нойрмоглох шинж цөөн, тунг 400мг хүртэл ихэсгэхэд олон тохиолдоно. Ихэнх тохиолдолд нойрмоглох шинж нь эмчилгээний 2-5 өдрийн дотор арилдаг.

Гистафен нь загатнааны улмаас нойргүйдсэн өвчтөний нойрыг сайжруулна.

Бэлдмэлийг өндөр тунгаар хэрэглэж байгаа үед ховор тохиолдолд түгшүүрэл, нойргүйдэл зэрэг гаж нөлөө олонтаа тохиолдож болно.

Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө хамаарна.

### 5. Гистафен бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25°C-с доош хэмд хадгална. Гэрэл болон чийгнээс хамгаалахын тулд үйлдвэрийн савлагаанд нь хадгална.

Бэлдмэлийг хүүхэд үзэж хүрэхээргүй газар хадгална.

Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй.

Ямар нэгэн бэлдмэлийг гэрийн бохирын ус болон ахуйн хогонд хаяж устгаж болохгүй. Цаашид хэрэглэгдэхгүй болсон бэлдмэлийг хэрхэн устгах талаар эм зүйчээсээ асуугаарай. Энэ нь хүрээлэн буй орчноо хамгаалахад тусална.

### 6. Савлалтын агууламж болон бусад мэдээлэл

**Найллага:**

Үйлчлэгч бодис: сехифенадины гидрохлорид 50мг.

Туслах бодис: Лактоз, бичил талст целлюлоза, эрдэнэ шишийн цардуул, кремнийн хоёрч исэл, магнийн стеарат.

**Гистафены дүрслэл болон савлалт:**

**Дүрслэл:** Цагаан буюу цагаавтар өнгөтэй, дугуй хэлбэртэй, хавтгай, налуу ирмэг бүхий, нэг талдаа хэрчлээс бүхий шахмал.

**Савлалт:** 10 шахмалыг блистертэй гаргах ба 20 шахмалыг эм хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлаж гаргана.